



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 0/293

Улаанбаатар хот

Нийслэлийн Байгаль орчны газрын  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас  
хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 18,086,545.66 /Арван найман сая наян зургаан мянга таван зуун дөчин таван төгрөг жаран зургаан мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан минжийг байгальд сэргээн нутагшуулж байгаатай холбогдуулж данс бүртгэлээс хасахыг нийслэлийн Байгаль орчны газар /Э.Баттулга/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 18,086,545.66 /Арван найман сая наян зургаан мянга таван зуун дөчин таван төгрөг жаран зургаан мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 4 ширхэг минжийг нийслэлийн Байгаль орчны газрын даргын 2019 оны А/74 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохиох журмын дагуу акт үйлдэн байгальд тавьж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг нийслэлийн Байгаль орчны газар /Э.Баттулга/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 08 сарын  
 12 өдрийн 07213 дугаар тушаалын хавсралт



Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Байгаль орчны газар

№	Эд хөрөнгийн нэр	Нас	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХКомиссын хурлын шийдвэр
1	Минж	3	ш	1	7,421,932.66	7,421,932.66	-	-	Байгальд сэргээн нутагшуулах	Байгальд тавих
2	Минж	5	ш	1	6,900,695.00	6,900,695.00	-	-		Байгальд тавих
3	Минж	3	ш	1	1,881,959.00	1,881,959.00	-	-		Байгальд тавих
4	Минж	3	ш	1	1,881,959.00	1,881,959.00	-	-		Байгальд тавих
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>				<b>4</b>		<b>18,086,545.66</b>	-	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө						18,086,546				
Татан төвлөрүүлэх хөрөнгө								-		
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/										